



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

Г “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилтыг үргэжлүүлэн хангуулах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Улсын их хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.2, Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолын 3 дахь заалт, Хорооны 2012 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн ажиллах дүрмийн 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.6 дахь хэсгийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийн эцсийн тайланг хэлэлцэж дэмжсэн тул Засгийн газарт танилцуулж, нийтэд мэдээлэхийг Компанийн засаглалын үндэсний зөвлөл /Д.Ганбаяр/-д зөвшөөрсүгэй.

2. “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хугацаа дуусч байгаа хэдий ч олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн, нийтийн ашиг сонирхолын төлөө ажилладаг компаниудын засаглалыг илүү сайжруулах шаардлага байгааг харгалзан хөтөлбөрийн зорилтыг үргэлжүүлэн хангаж ажиллахыг Компанийн засаглалын үндэсний зөвлөл /Д.Ганбаяр/-д даалгасугай.

3. Санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, компанийн засаглалын үнэлгээ хийж олон нийтэд мэдээлэх, компанийн ил тод байдлыг хангуулах зэрэг бусад ажлыг Компанийн засаглалын үндэсний зөвлөл нь төр, хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр мэргэжлийн институтын түвшинд үйл ажиллагаа явуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-д даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА